



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 0122

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.1, 51.1.4 дэх заалтууд, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4, 6 дугаар хавсралтууд, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ур чадварын нэмэгдэл олгох, дүгнэх журмыг нэгдүгээр, Үр дүнгийн урамшуулал олгох журмыг хоёрдугаар, Байгууллагын хөдөлмөрийн аварга, байгууллагын шилдэг ажилтан шалгаруулах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх журмуудыг хэрэгжүүлж ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2018 оны А/17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ХЭРДЭНЭБИЛЭГ

1150500044